



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/50

Улаанбаатар хот

Г Хөрөнгө бүртгэж авах тухай Г

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.4 дэх заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2015 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн А/329 тоот тушаал, Газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэр хорооллын орон сууцжуулах төсөл” ОНӨҮГ-ын балансаас шилжин ирж байгаа нийт 477.676.000 /дөрвөн зуун далан долоон сая зургаан зуун далан зургаан мянга/ төгрөгийн үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө /2\*3 м хэмжээтэй төмөр хашаа/-г балансад бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан байгууллагын өмчид бүртгэгдэж буй эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга /О.Гантулга/, Санхүү аж ахуйн багийн ахлагч, нягтлан бодогч /Г.Батням/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Албаны дарга /Л.Мөнхтуяа/-д даалгасугай.

ДАРГА М.ГОНЧИГЖАВ



3150600069